



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/188

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хүүхэд багачуудын урлагийн авьяасыг хөгжүүлэх, ардын өв соёлоо хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор 2 жил тутамд уламжлал болгон зохиодог хүүхдийн урлагийн "Яргуй" наадмыг 2017 онд сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд зохион байгуулахтай холбогдуулан аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Санхүүгийн дэмжлэгт шаардлагатай 1500000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Яргуй урлагийн наадмыг өндөр хэмжээнд зохион байгуулахыг Гэр бүл, хүүхэд залуучуудын газар /Б.Энх-Эрдэнэ/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

011000